



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/676

Мөрөн сум

Ажиллах хүч, ажлын байрны
мэдээллийг сайжруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн үндсэн ажлын байр, ажиллах хүчний мэдээллийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор, шинээр бий болсон ажлын байр, ажилтны мэдээлэл, ажиллах хүч, ажлын байрны шилжилт хөдөлгөөний мэдээллийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор, сул ажлын байрны захиалга мэдээллийг тухай бүр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ирүүлэхийг төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

2.Төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн үндсэн ажлын байр, ажиллах хүч, шинээр бий болсон ажлын байр, ажилтны мэдээлэл, ажлын байрны шилжилт хөдөлгөөний мэдээллийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэн ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Т.Раднаабүд)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Гандэлгэр)-т даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР